




МОНГОЛ ДАГУУРЫН ХЭЭРИЙН ЭКО-БҮС НУТАГ

Манай дэлхийн байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангахад хамгийн их ач холбогдол бүхий зайлшгүй хамгаалах 200 глобал эко-бүс нутгийг Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF) тодорхойлон зарласан билээ. Энэ 200 глобал эко-бүс нутгийн хоёр нь болох Алтай-Соёны болон Дагуурын хээрийн эко-бүс нутгуудын зарим хэсэг манай Монгол оронд байдаг (Зураг 1). Дагуурын хээрийн эко-бүс нь Орос, Хятад, Монгол улсын нутаг дэвсгэрийг дамнан орших ба энэ эко-бүс нутагт Дагуурын ойт хээрийн, Монгол Манжуурын хээрийн гэсэн 2 дэд бүс багтана (Зураг 2).



Зураг 1. Алтай-Соён ба Дагуурын хээрийн эко-бүс нутгууд



Зураг 2. Дагуурын ойт хээр, Монгол Манжуурын хээр, Монгол улсын эдийн засгийн зүүн бүс болон Амар мөрний сав газар

далайн ай сав гэж бас нэрлэдэг. Амар мөрний сав газрын Монгол дахь хэсгийн ус хураах талбайн нийт хэмжээ 235,000 орчим км² бөгөөд энэ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 15%, Амар мөрний ай савын нийт талбайн 11% орчимтой тэнцүү юм.

Амар мөрний савын Монгол дахь хэсэг дотроо 4 голын сав нутгаас бүрдэнэ. Үүнд: 1) Онон голын сав нутаг, талбай нь 30000 км² орчим; 2) Улз голын сав нутаг, талбай нь 35000 км² орчим; 3) Хэрлэн голын сав нутаг, талбай нь 145000 км² орчим; 4) Халх голын сав нутаг, талбай нь 25000 км² орчим.

Монгол Улсын засаг захиргааны хувиараар авч үзвэл Амар мөрний ай савд Дорнод, Хэнтий хоёр аймгийн нутаг бүхэлдээ багтахгаас гадна Төв аймгийн 3 сум (Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баянжаргалан), Сүхбаатар аймгийн 4 сумын (Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан) нутаг хамрагдана.

Тус сав нутгийн газарзүйн байрлалыг математик координатын үзүүлэлтээр тодорхойлбол баруунаас зүүн тийш зүүн уртрагийн 107°45'-аас 119°57' хүртэл, хойноос урагшаа хойт өргөрөгийн 50°20'-аас 45°20' хүртэлх зайцад оршино.

Монгол улсын нутаг дахь Амар мөрний ай сав нь бүхэлдээ эдийн засгийн “Зүүн Бүс” нутагт багтана. Мөн Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гаас тодорхойлсон зайлшгүй хамгаалах 200 глобал эко-бүс нутгийн нэг болох Дагуурын хээрийн эко-бүс нутагтай давхцана.


2. Эдийн Засгийн “ЗҮҮН БҮС”

Монгол улс нийгэм-эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулан нутаг дэвсгэрээ бүсүүдэд хуваан хөгжүүлж байна. Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгууд нь бүхэлдээ эдийн засгийн “Зүүн бүс”-д багтана.

3. Онон голын сав газар

Монголын нутаг дахь Амар мөрний сав газарт Онон, Улз, Хэрлэн, Халх гол болон тэдгээрт цутгадаг 400 гаруй гол, горхи багтана. Эдгээрээс байнгын урсгалтай голуудын нийт урт 2000 орчим км юм.

Онон гол Их Хэнтийн нуруу, Хэнтий Хан уулын араас эх авч Монгол улсын Хэнтий, Дорнод аймаг, ОХУ-ын Чита мужын нутгаар нийт 808 км урсаад, ОХУ-ын нутагт орших Хэнтийн нурууны зүүн хойш үргэлжилсэн хэсгийн ноёлох оргил Сохонд хайрханы араас эх аван урсах Ингэдэй голтой нийлэн Шилк мөрнийг үүсгэнэ. Шилк мөрөн ОХУ-ын нутгаар 555 км урсаад Эргүнэ мөрөнтэй нийлэн Амар мөрнийг үүсгэнэ. Амар мөрөн цааш 2834 км урсан



Зураг 3. Монгол Улсын нутагт хамрагдах Амар мөрний сав газар

Номхон далайн Агнуурын тэнгисийн Татаарын хоолойд цутгана. Ийнхүү Ононгийн эхнээс гадаад далай хүртэл 4444 км урт замыг ямар нэгэн хаалт далангүй чөлөөтэй урсаж байгаа дэлхийн 5-том мөрний нэг бол Амар юм. Онон голын нийт ай савын талбай нь 96 000 кв км. Монгол улсын нутгаар 298 км урсана. Ононгийн нийт сав газрын 30,3 % нь болох 29070 кв км газар нутаг Монголд байна. Онон голын ус эрдэсжилт багатай, бохирдолгүй, маш зөөлөн чанартай. Онон голын усны жилийн дундаж урсац Биндэр орчимд 52,6 м³/сек, Дадал орчимд 59,6 м³/сек, хилийн чанадад Битэв тосгоны орчимд 102 м³/сек байдгаас харахад усны урсацын алдагдал байхгүй гэхэд болно.

Онон гол нь Бурхан Халдун уулнаас эх аваад Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Хужир нуга хүртэл битүү шилмүүст ой хөвчтэй өндөр уулсын дундуур маш өтгөн ургасан торлог шугуйтай битүү намаг бүхий хөндийгөөр урсана. Энэ хэсэг бол Онон голын үндсэн төрх бүрдэх ус цуглуулах талбай юм. Эндээс цааш Хэнтий аймгийн Биндэр сумын төв хүртэл ой мод ихтэй өндөр уулсын дундуур өтгөн их ургасан бургасан шугуйтай нарийн хөндийгөөр урсана. Энэ хэсэгтээ уулын голын шинжтэй. Биндэр сумын

төвөөс Баян-Адрага сумын нутаг Шуусын голын адаг хүртэл намхан уулстай ойт хээрийн дундуур урсана. Энэ хэсэгт хөндий нь өргөсч тал хээрийн голын шинжтэй болно. Шуусын голын адгаас улсын хил хүртэл дахин ой хөвчтэй уулсын дундуур нарийн хөндийгөөр урсаж дахин уулын голын шинжтэй болдог.

Онон голд том жижиг олон голууд цутгадаг. Эдгээрээс том нь Балж, Хэр, Агац, Хурх, Барх, Эг, Шуус, Гурван Тарс, Гурван Сүүхлэг, Хүе, Ашинга, Хушинга, Улаан байц, Бэрлэг, Хайрхан, Турагтхаан, Ар Өнөрч, Ар Эрээн зэрэг голууд юм. Балж гол бол Ононгийн хамгийн том цутгал гол бөгөөд ОХУ-ын нутаг Хэнтийн нурууны үргэлжлэл Хөмөлийн сарьдаг уулаас эх аван урсаж монголын нутгаар 160 орчим км нийт 200 гаруй км урсаад Ишийн хад уулын орчимд Ононд нийлнэ. Балж голд Хирхун, Бөххүн, Амгалант, Хөмөл, Галттай, Хөтөлж зэрэг томоохон голууд цутгадаг.

Онон голын эхэнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт далайн түвшинээс дээш 1450 м өндөрт Ононгийн халуун рашаан байдаг. Энэ рашаан нь гидрокарбонат натри, магни хүхрийн найрлагатай цельсийн 80 градус халуунтай олон төрлийн өвчнийг анагааж эмчлэх чадвартай. Мөн Ононгийн сав нутгаар Тарсын, Улаалзарганын, Цагаан чулуутын, Хажуу булгийн зэрэг эмчилгээны сайн чанартай рашаанууд байдаг. Дадал сумын нутагт байдаг Хүрхрээ нуур, Өмнөдэлгэр суманд байдаг Хангалын нуурууд гадагшаа урсгалтай цэнгэг устай. Хүрхрээ нууранд гурван Яамнайн голууд цутгаж гадагшаа нуурын хоолойгоор урсан Хирхуны голд нийлнэ. Энэ нууранд амарын цурхай, мөнгөлөг хэлтэг зэрэг загас элбэг байдаг. Дадал сумын Галттайн голын хөндийд Их цагаан, Бага цагаан, Наадамын, Биндэр сумын Хурхын хөндийн Булангийн, Биндэр, Цэгээн зэрэг давстай нуурууд бий. Эдгээр нуурууд нь олон зүйл усны шувуудын өндөглөн зусдаг нутаг болно.

Онон голын эхэн хэсэг буюу Биндэр сум хүртэл далайн түвшинээс дээш 1500 –2200 м өндөр шилмүүст ойгоор битүү бүрхэгдсэн Дуут ян, Алаг ян, Тарсын тэгсгэр, Ноён уул, Улаан байц уул, Жарангуут, Их Сүүхлэг ян, Зэлээнд, Турагтхаан, Төөрдөгийн шил зэрэг уулс тэдгээрийн хоорондын нарийн хөндийнүүдэд амьтан ургамалын олон зүйл байдаг. Эндээс доош Онон-Балж голуудын сав нутаг нь нарс, хар мод, хус голлон ургасан холимог ой бүхий далайн түвшинээс дээш 1300 – 1500 м өндөр Хэнтийн нурууны зүүн салбар уулсууд болох Хэцүүгийн шил, Тэхрүү уул, Хавтгайн хяр, Шувуутын шил, Халзан бүргэдтэйн нуруу, Баян хааны уулс, Эрээн давааны нуруунууд тэдгээрийн хөндийгөөр олон гол горхи урсан байгалийн үзэмж бүрдсэн.

Ононгийн сав газраар Монгол орны ойн, ойт хээрийн, хээрийн амьтад элбэг тархсан байдаг. Онон, Балж болон тэдгээрийн цутгал голуудад Амар мөрний савын олон зүйлийн загас амьдардаг. Тул, амарын цурхай, зэвэг, мөнгөлөг хэлтэг, алтлаг хэлтэг, булуу цагаан, амарын сугас, хадран, цулбуурт загас,

гутаарь зэрэг загас элбэг тохиолдоно.

4. Онон-Балжийн байгалийн цогцолборт газар

Монгол Улсын Их Хурлын шийдвэрээр 2000 онд Онон-Балжийн сав нутгийн Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Норовлин, Дорнод аймгийн Баян-уул сумын нутгийг хамруулсан 415752 га талбайг Байгалийн Цогцолборт газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтанд авч Онон-Балжийн Байгалийн Цогцолборт Газар (БЦГ)-ыг байгуулсан. БЦГ нь хойт талаараа Оросын нутаг сибирийн тайгатай хиллэж урдуураа хээрийн бүстэй залгаж орших ба Монголын “улаан ном”-д бүртгэгдсэн Дагуур шинэс, Крыловын нарс зөвхөн энд ургадаг. Амьтны аймгийн хувьд ихээхэн өвөрмөц, ховор зүйлүүд цөөнгүй. Улаан номд орсон болон ховорт тооцогдох баданга хүдэр, бараан хандгай, дагуур зараа, нохой зээх, шилүүс мий зэрэг 10 орчим зүйлийн хөхтөн энд бий. Онон, Балж голд Зүүн Азийн төлөөлөгч болох олон зүйл (54 зүйл) усны амьтантай, ялангуяа зөвхөн Амур мөрөнд байдаг хорхой загас, Амур мөрний хилим, цагаан хадар, шанага загас мэтийн ховор загас, дугуй амтан, голын хавч, дагуурын сувдан хясаа мэтийн цэнгэг усны өвөрмөц зүйл амьтныг зөвхөн энд л харж болно. Мөн улаан номд бүртгэгдсэн 10 гаруй зүйл шувуу энд бий.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь Хөтөлбөрийн газраас боловсруулав.

Дэлгэрэнгүй мэдээллийг batnasan@wwf.mn , gankhuayag@wwf.mn хаягаар авч болно.